

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ 3 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

1.1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан 3 дугаар сард хийгдээгүй.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдэд нөхөн олговор олгох ажлын хүрээнд 3 хүний материалыг сонинд зарлуулсан бах хилс хэрэгт хэлмэгдэгчдийн үр хүүхдүүдэд нийт 1,400,000,000.0 төгрөгийг олгосон.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл нь энэ оны 3 дугаар сарын 5-ны өдөр хуралдаж, 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 5 бүлэг 42 заалттайгаар батлав.

Мөн 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдөр аймгийн ГХУСАЗСЗ-ийн хуралдаан хуралдаж, бичил төсөл шалгаруулах ажлын хэсгийг байгуулж, анхны тогтоолоо гаргасан болно.

Аймгийн ИТХ-д иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс 42 аялал бичиг ирсэн бөгөөд аймгийн ИТХ-аас 34 аялал албан бичиг явуулж, иргэдийн биечлэн болон бичгээр өргөдөл, хисэлтийг холбогдох газарт уламжилж, шийдвэрлэх боломжтой асуудлыг тухай бірт нь шийдвэрлэсэн байна.

Аймгийн ИТХ-д 3 дугаар сарын байдлаар нийт 11 өргөдөл, гомдол ирснийг төрлөөр нь ангилбал ажил хүсэх тухай 3, тусламж хүсэх тухай 1, хүсэлт тавих тухай 4, тус тус ирсэн байна. Өргөдлийн дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлж албан бичгээр уламжлав.

1.2. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

Аймгийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн 3 дугаар сард хуралдаагүй болно.

Баян-Өлгий аймгаас гадаад улсад түр болон удаан хугацаагаар суралцаж, ажиллаж амьдарч буй иргэдийн судалгааг бүх сумдаас авч нэгтгэн Тагнуулын ерөнхий газрын тус аймаг дахь газарт хүргүүлэв.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48-р зүйлийн 48.5-д “Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг “Монголын үнэн” сонины 2020 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн №001 /23989/ дугаарт гаргаж, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем

<https://www.tender.gov.mn/> болон аймгийн Засаг даргын Тамгын газрын <http://bayan-olgii.gov.mn/> албаны веб сайтад нийтэлсэн болно.

Аймгийн Засаг дарга 3 дугаар сарын 3-ны өдөр “0-10 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийн ажлын цагийг хорогдуулах тухай” А/132 дугаар захирамж гаргаж, коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, бага насны хүүхдийг болзошгүй аюулаас хамгаалах, аюулгүй байдлыг хангах зорилгоор 3 дугаар сарын 30-ныг хүртэл аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагад ажилладаг 0-10 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүд болон 0-10 насны хүүхэдтэй ганц бие эцгүүдийн өдөр тутмын ажлын цагаас 1 цагийг хорогдуулан ажиллуулахыг байгууллагын удирдлагуудад зөвшөөрч, мөн хамаарах ажилтны албан үүргийн зохицуулалтыг зохион байгуулж, байгууллагын хэвийн ажиллагааг хангах, тухайн ажилтны цалин хөлсийг бүтэн ажилласанд тооцож олгохыг үүрэг болгов.

Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Онцгой комиссын 13 дугаар хуралдаанаас гаргасан тус аймгийн төвийн авто замын хөдөлгөөнийг 2020 оны 03-р сарын 22-ны өдрийн 10:00 цагаас 20:00 цагийн хооронд түр хязгаарласан шийдвэрийг ард иргэд хариуцлагатайгаар хүндэтгэн биелүүлсэн.

Шинэ төрлийн коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор МУ-ын Засгийн газар, Улсын Онцгой комиссоос үндэсний хэмжээнд ариутгал, халдваргүйжүүлэлт хийх шийдвэр гаргасан юм.

Энэхүү шийдвэрийн дагуу 3 дугаар сарын 23-ны өдөр аймгийн Онцгой комиссын шуурхай штаб хуралдаж, аймгийн гудамж талбай, ялангуяа олон нийт ихээр зорчдог газарт ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг нэгдсэн зохион байгуулалттайгаар хийхийг холбогдох албаныханд үүрэг болгов.

1.2.1. Өргөдөл, гомдлын талаар

2020 оны 3 дугаар сард аймгийн Засаг даргын Тамгын газарт нийт 110 өргөдөл ирүүлснээс бичгээр 104, аймгийн ИТХ-аас 6 өргөдөл шилжүүлсэн байна.

Эдгээрээс 89 өргөдлийг хэлтэс, агентлагуудад шийдвэрлүүлэхээр уламжилсан, одоогоор шийдвэрлэх шатандаа явж байгаа ба 21 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж иргэдэд хариу өгсөн болно.

Ирүүлсэн 110 өргөдлөөс:

- Ажил хүссэн 30
- Хүсэлт тавих тухай 19
- Гомдол 7
- Тусламж хүссэн 15
- Эмчилгээний зардал хүссэн тухай 4
- Чөлөө 3
- Замын зардал хүссэн тухай 1
- Нэвтрэх зөвшөөрөл хүссэн 29
- Газрын маргаан шийдвэрлүүлэх тухай 1

- Тусгай зөвшөөрөл хүссэн 1 өргөдөл тус тус ирүүлсэн болно.

ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2.1. Хууль хяналтын үйл ажиллагаа

2.1.1. Хууль, эрх зүйн хэлтсийн мэдээлэл

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс нь аймгийн Засаг даргын 91 ширхэг А захирамж, 7 ширхэг Б захирамжийг хянаж, тус буюу хууль тогтоомжийн лавлах санд хууль, Улсын Их Хурлын болон Засгийн газрын тогтоол, эрх зүйн хэм хэмжээний актыг шинээр бүртгээгүй, иргэдээс амаар болон бичгээр гаргасан хүсэлт, өргөдлийг хүлээн авч, 6 хүнд зөвлөгөө өгч үйлчлэв. Мөн согтууруулах ундаа худалдах нөхцөл, шаардлагыг хангаж, улсын тэмдэгтийн хураамж төлсөн 8 дэлгүүрт спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаагаар шинээр зөвшөөрөл олгов.

1.Архивын тасгийн мэдээ.

Иргэдээс 121 өргөдлийг хүлээж авч, 2236 хадгаламжийн нэгжийг ашиглаж 180 лавлагаа, 520 хуудас баримтыг хуулбараар олголоо.

Харилцагч байгууллагуудаас 7 албан бичиг ирснээс 7 хугацаатай албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлж, байгууллагуудад 13 албан бичиг хүргүүлж ажиллав.

Толбо сумаас 2000-2018 оны мал тооллогын баримтыг хүлээн авлаа.

Байгууллагуудын архив, албан хэрэг хариуцсан 4 хүнд зөвлөгөө өгөв.

2.1.2. Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээлэл /өссөн дүнгээр/

1	Иргэдийн баримт бичгийн зөрчлийн арилгалт хувь	99,9
2	Шилжих хөдөлгөөн хот /шилжиж ирсэн аймаг хотоос/	-
3	Шилжих хөдөлгөөн хот дотор /сум, багаас/	-
4	Гадаад паспорт эзэмшигчдийн тоо	319
5	Шинээр гэрлэлт /тоо/	43
6	Нас баралтын бүртгэл	45
7	Төрсний гэрчилгээний бүртгэл	228
8	Үрчлэлт	14

2.2. Гэмт хэргийн талаарх мэдээлэл

№	Заалт	Биелэлт, хувь , тоо
1	Цагдаагийн газрын нийт хүлээн авсан гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй өргөдөл, гомдол мэдээлэл	608
2	Бүх гэмт хэрэг	115

3	Гэмт явдлын улмаас гэмтсэн	47
4	Гэмт хэргийн улмаас нас барсан хүн	4
5	Малын хулгайн гэмт хэрэг	16
6	Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг	16
7	Нийт учирсан хохирол /сая.төг/	183,3 буюу 90 сая төг
8	Баривчлагдсан хүн	53
9	Зөрчлийн хуулиар хэдэн хүнийг хэдэн сая ᠔᠐᠗᠔᠗᠔᠗᠔᠗ торгож, арга хэмжээг авч ажилласан байдал	2705 хүнийг 118250,0 төгрөгөөр торгов.
10	Саатуулагдсан хүний тоо	302
11	Камераар илрүүлсэн зөрчил	404
12	Нийт зөрчил	2845

2.3. Онцгой байдлын чиглэлээр

Коронавирус “Covid-19”-ийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд Засгийн газрын тогтоол, Улсын Онцгой комиссын тогтоол, хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Онцгой комиссын хурлыг 8 удаа хуралдуулж, 28 асуудал хэлэлцэж 36 төрлийн шийдвэр гаргаж хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж ажиллалаа.

Аймгийн Онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2020 оны А/113, А/115, А/116, А/117, А/118, А/125, А/127, А/132, А/139, А/148, А/165, А/165 А/166, А/179, А/180 дугаар захирамжуудыг гаргаж зорчигч тээврийн зорчих хөдөлгөөнийг түр зогсоох, хугацааг сунгах, хөрөнгө гаргах, шуурхай штабын бүрэлдэхүүн томилох, ажлын тусгай горимд шилжүүлсэн хугацааг сунгах, 0-10 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийн ажлын цагийг багасгах, тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулахгүй байх тухай, коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай, коронавируст халдвар бүртгэгдсэн улс орноос ирсэн иргэдийг тусгаарлах тухай зэрэг 38 төрлийн зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор Засгийн газрын 2020 оны 30, 39, 62, 63, 64, 68 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 1-6 дугаар тогтоол, мөн 1-13 дугаар хурлын шийдвэрийн аймгийн Засаг даргад хамаарах хэсэг 38 заалтын биелэлтийг заалт бүрээр гаргаж албажуулан Улсын Онцгой комиссын ажлын албанд хүргүүлэв.

Албан бичгээр ирүүлсэн хугацаат үүргийн дагуу Улсын Онцгой комиссын 2020 оны 06, 07, 08 дугаар хурлын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд хийсэн ажлын илтгэх хуудас, тусгаарлах байрны байршил, судалгааг гаргаж Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн шуурхай удирдлагын газарт хүргүүлэв.

Энэ хугацаанд улсын онцгой комиссын 2 удаагийн шийдвэр, аймгийн Засаг даргын 2 удаагийн захирамжаар аймаг, сумын төвөөс гарах, орох тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг түр зогсоосонтой холбогдуулан 19 хоног хүнс, шатахуун, өвс, тэжээл тээвэрлэлтийн 163, эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээний 58, албан томилолт, харуул манаа, ээлж солилцох 108, ар гэрийн гачигдалтай 213 нийт 542 тээврийн хэрэгсэл, 3039 хүнийг хяналтын цэгээр нэвтрэх зөвшөөрөл олгосон.

Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд аймгийн Онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийн дагуу Бүгд Найрамдах Казахстан Улсаас 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр ирж гэрт тусгаарлагдсан 59 иргэдийн эрүүл мэндийг ажиглах 14 хоногийн хугацаа дуусах хугацаа буюу 03 дугаар сарын 26-ны өдөр хүртэл аймаг, сумын төвөөс гарах, орох зорчигч тээврийн зорчих хөдөлгөөнийг аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/179 дүгээр захирамжаар түр зогсоосон байхад хөдөлгөөний хязгаарлалтыг зөрчсөн 1 иргэнийг зөрчлийн тухай хуулийн 13.5.1-т заасны дагуу нэг зуун тавин нэгжээр торгох шийтгэл ногдуулсан.

ГУРАВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

3.1. Эрүүл мэндийн чиглэлээр

Аймгийн Засаг даргын 2020 оны А/132 дугаар захирамжийг үндэслэн Эрүүл мэндийн газрын даргын 03 дугаар сарын 06-ны өдрийн А/10 дугаар тушаалаар 0-10 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийн ажлын цагийг 1 цагаар хорогдуулах тухай тушаал гарч хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Манай аймагт бүртгэгдсэн коронавирусын халдварын 4 удаагийн сэжигтэй тохиолдолд эрүүл мэндийн ажилтан, амралтын өдөр болон ажлын бус цагаар тархвар зүйн судалгаа, шинэ коронавирус өвчний үед зохион байгуулагдах үйл ажиллагаа, бэлэн байдлыг хангах, ор дэлгэхэд холбогдох тооцоо судалгаа хийх ажлаар давхардсан тоогоор 168 эрүүл мэндийн ажилтан 5-12 цагаар ажилласан бол Ховд-Өлгийн чиглэлийн постод 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс 24 цагаар 70 эрүүл мэндийн ажилтан, Онгоцны буудалд 23 эрүүл мэндийн ажилтан, Авто тээврийн газарт 35 их эмч 12 цагаар, Эрүүл мэндийн газарт шуурхай штабын жижүүрээр 70 эрүүл мэндийн ажилтан, ЗДТГазарт шуурхай штабт 12 ажилтан, Казахстан улсаас ирсэн иргэдийг тусгаарлаж байгаа ажиглалтын 4 байранд 2020 оны 03 дугаар сарын 14-18-ны хүртэл 38 эрүүл мэндийн ажилтан, давхардсан тоогоор нийт 503 ажилтан дайчлагдан ажилласан.

Харьяа эрүүл мэндийн байгууллагын дарга, эрхлэгч, ажилтан албан хаагч нар ЭМГазрын дарга, хэлтсийн дарга, анхан шат хариуцсан мэргэжилтнүүдийн хамтарсан цахим хурал болж, коронавируст халдвараас сэргийлэх чиглэлээр мэдээлэл, зөвлөгөө мэргэжлийн удирдлагаар хангаж, Засгийн газар, Улсын онцгой комисс, Эрүүл мэндийн яам, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан журам, заавар, зөвлөмжийг танилцуулж, бэлэн байдлыг хангах, ажилтан албан хаагч нэг бүрээр судлуулж мөрдүүлэх талаар үүрэг даалгавар өгч, эрүүл мэндийн газрын ажилтан албан хаагч нарт нэг бүрчлэн танилцуулсан.

Жансая, Мейрим, Рауан, Шипагер өрхийн эрүүл мэндийн төвүүдэд Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын даргын 2020 оны 03 дугаар сарын 14-ний өдөр баталсан “Коронавируст халдварын үед иргэнийг тусгаарлах, ажиглах түр журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2, 9.6 дахь заалтын хэрэгжилтийг хангуулан гэрийн ажиглалтад байгаа иргэдэд эрүүл мэндийн тандалт хийж, гэртээ тусгаарласан иргэн бүрээс хяналтын хуудасны дагуу биеийн халууныг өдөрт 3 удаа утсаар авч, тус журмыг мөрдөн ажиллаж байна.

Казахстанаас улсаас ирсэн иргэдийг тусгаарлан ажиглалтанд авах байруудыг Өлгий сумын төвийн МСҮТ-ийн дотуур байранд 100 ор, 6 дугаар ахлах сургуулийн дотуур байранд 100 ор, Эмпати сургуулийн дотуур байр 200 ор, Автотээврийн байр 23 ор, Owl sky зочин буудал 19 ор, Өркен зочид буудалд 10 ор, Пазилет ТББ-ын байранд 72 орыг бэлдэж, ажиглалтын байранд 344 хүнийг ажиглаж, 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 232 хүнийг тусгаарлан ажиглах байрнаас гэрийн ажиглалтад шилжсэн. Мөн аймгийн төвийн орны нөөц хэтэрсэн тохиолдолд ойр байгаа сумдыг дайчлан ажиллах зорилгоор Сагсай сумын сургуулийн дотуур байранд 120, ЭМТ-д 28 ор, Улаанхус сумын сургуулийн дотуур байранд 120 ор, ЭМТ-д 40 ор, Бугат сумын сургуулийн дотуур байр 25 ор, ЭМТ-д 40 ор, ЭМТ 10 ор, Цагааннуур тосгоны эрүүл мэндийн төвийн 15 ор, сургуулийн дотуур байранд 40 ор, Улаанбайшинтийн Гаалийн лабораторийн байрыг үзлэг хийж, тандалт хийх, түр саатуулах байр болгон тус тус ашиглахаар төлөвлөн ажиллаж байна.

Эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа хүн хүч, хүчин чадал, дайчлан ажиллах хүний нөөц, ажиглалтын байранд ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд 2018-2021 онд төрийн санхүүжилтээр манай аймгийн захилгаар сурч байгаа 32 эмчийг, тэтгэвэрийн насны болон хүний нөөцийн судалгаанд бүртгэлтэй эмч, сувилагчдын судалгааг байгууллага тус бүрээр гаргаж, тухайн эмч, сувилагчаас зөвшөөрөл авч, аймгийн Нэгдсэн эмнэлэг болон сумдын амбулаторийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд дайчлан ажиллуулахаар төлөвлөсөн.

Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор ЗӨСҮТөвийн ерөнхий захирлын 2020.02.21-ний өдрийн А/15 дугаар тушаалаар баталсан “Коронавируст (COVID-19) халдварын үед халдваргүйжүүлэлт хийх тухай түр заавар”, ХӨСҮТөвийн ерөнхий захирлын “Коронавируст (COVID-19) халдвараас урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийх зааварчилгаа”, үйлчилгээний байгууллагад өгөх зөвлөмжийг аймгийн Шуурхай штабаар дамжуулан албан бичгээр бүх сумдын Засаг дарга нарт болон нэр бүхий нийт 83 төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд хүргүүлсэн.

Шаардлагатай нөөц бүрдүүлэх чиглэлээр сумдын Засаг дарга нартай утсаар холбогдож зөвлөмж өгсөн. Үүний үр дүнд Цэнгэл сум 500.000 төгрөгний халдваргүйтгэх бодис, 1 тонн бензин, Улаанхус сум 1.200.000 төгрөг, Дэлүүн сум 20ш хамгаалах хувцас, Цагааннуур тосгоны 350.000, Ногооннуур сум 200 ор, 200 ширхэг маск, Сагсай 200 ор,

Толбо сум 30 хамгаалах хувцас, 30 ор, Буянт сум 20 ширхэг хувцас, Бугат сум 20 ш хувцас авч тус тус нийлүүлсэн байна.

Монголын Эмэгтэйчүүдийн холбооны Баян-Өлгий аймгийн салбар зөвлөлийн тэргүүлэгчид Коронавирусийн болзошгүй халдвараас урьдчилан сэргийлэх, шуурхай хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангаж ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтнуудад шаардлагатай хамгаалах хувцас, халдваргүйжүүлэх бодисын нөөц бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулж, өөрсдийн гараар оёсон, өндөр даралтын уураар ариутгаж халдваргүйжүүлсэн, зориулалтын уутанд савласан, зөв хэрэглэх заавартай 1000 ширхэг /маск/ амны хаалтыг хүлээлгэн өгсөн.

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Б.Нургулан Коронавирусийн болзошгүй халдвараас урьдчилан сэргийлэх, шуурхай хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангаж ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтнуудад шаардлагатай хамгаалах хувцас, халдваргүйжүүлэх бодисын нөөц бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулж, байгууллагаасаа 100 ш маск, хувиасаа 100 мянган төгрөгийн хандив өгсөн.

Эрүүл мэндийн газрын хамт олон 100 ш маскийг өөрсдөө оёж, нөөцөд бэлтгэсэн.

Орон нутгийн радио, Саян, Дербес ТВ-гээр маскийг зөв хэрэглэх, халдваргүйтгэл хэрхэн хийх, гараа хэрхэн зөв угаах, цаг үеийн мэдээлэл, ажиглалтад байгаа хүмүүст, иргэдэд хүргэх зөвлөмж сэдвүүдээр 40 удаагийн зөвлөгөө өгсөн.

Байгууллагын Facebook хуудсанд корона вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх тухай 146 төрлийн мэдээлэл, зөвлөгөө, талархал оруулж, 330920 хандалт авч, 1718 хүн хуваалцсан байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас ирсэн хяналт шалгалтын явцад аймгийн Нэгдсэн эмнэлэг, Цагааннуур тосгоны эрүүл мэндийн төв, 4 өрхийн эрүүл мэндийн төвүүдэд ажиллаж, гарсан алдаа дутагдлыг засах албан шаардлагын дагуу 5 баг болж хуваагдаж, зөвлөмжийн биелэлтийг гаргаж, МХЕГ-т хүргүүлсэн.

ДӨРӨВ. ХӨДӨӨ, АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

4.Хөдөө аж ахуйн чиглэлээр

Тус аймгийн 13 сум 100 багт 2,190,000 мянган толгой мал өвөлжиж байна. 3 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар нийт төллөх 888153 хээлтэгчээс 205722 хээлтэгч төллөж төллөлт 23,2 хувтай байна. Гарсан төлөөс 906 төл хорогдож 204816 төл эсэн мэнд бойжсон ба төл бойжилт 99,6%-тай байна.Оны эхний малаас 1902 толгой мал зүй бусаар хорогдож малын онд оролт 99,9%-тай байна. Мал аж ахуйн өвөлжилт хэвийн явагдаж байна.

Коронавирусын хорио цээрийн дэглэмтэй холбоотойгоор энэ онд төлөвлөгдсөн сүү, мах, цагаан идээний үзэсгэлэн худалдаа явагдсангүй.

Коронавирус болон томуу, томуу төст өвчний дэгдэлттэй холбоотой улс даяар онц байдал тогтоож байгаатай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны А/167 тоот захирамжаар ажлыг хэсэг байгуулан орон нутгийн хүнсний нөөцийн судалгааг гаргаж аймгийн Онцгой комисс, ХХААХҮЯамд хүргүүлэн ажиллав.

Малын цэг зэмийг устгах, халдваргүйжүүлэх сарын аяныг зохин байгуулах тухай захирамж гаргаж бүх сумдад үхсэн малын цэг зэм устгах, халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулав.

Аймаг байгуулагдсаны 80 жилийг угтаж хийх 80 бүтээлч ажлын нэг болох “Нэг сум-нэг брэнд” уралдааны болзол, ажлын хэсгийг Засаг даргын 2020 оны А/200 тоот захирамжаар батлуулан бүх сумд, байгууллагуудад хүргүүлэв.

ТАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

5.1. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр

3 дугаар сарын байдлаар Сангийн яаманд 2019 оны аймгийн болон сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний жилийн эцсийн тайланг хүргүүлсэн. Тухайн сарын байдлаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээс тус аймагт эрх нь шилжсэн 10 төсөл арга хэмжээний үнэлгээний хороог байгуулан худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж байна, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжихээр төлөвлөгдсөн нийт 12 ажлын үнэлгээний хороог байгуулан худалдан авах ажиллагаа явагдах шатанд байна. Мөн түүнчлэн 10,0 саяас доош төсөвт өртөгтэй шууд худалдан авахаар хэрэгжихээр төлөвлөгдсөн нийт 30 ажлын гэрээг байгуулсан.

5.2. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр

Аймгийн Засаг даргын А/239 дугаар захирамж, аймгийн онцгой комиссын 2020 оны 01 албан тоотын дагуу 24 цагийн ажиллагаатай шуурхай штаб байгуулан хариуцлагатай жижүүр ажиллуулж байна.

Аймгийн онцгой комиссоос гадаад, дотоодын жуулчдыг хүлээж авахгүй байх үүрэг даалгавар өгөгдсөн тул гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын /хагас/ зэрэгт шилжүүлсэн хугацаа дуустал жуулчин хүлээж авахгүй талаар албан бичиг боловсруулж холбогдох газруудад хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Дэлхийн байгалийн амьтан, ургамал хамгаалах өдрийг тохиолдуулан цахим, хэвлэл мэдээллээр сурталчилгааны ажлыг зохион байгууллаа.

Усны болон Ойн тухай хууль тогтоомжуудыг орон нутгийн хэвлэл мэдээллээр сурталчлах ажлыг зохион байгууллаа.

Улсын Онцгой комиссын шийдвэрийн дагуу байгууллагын 0-12 насны хүүхэдтэй эхчүүдийг хэсэгчилсэн хорио дуустал гэрээр /цахимаар/ ажиллах нөхцөлийг бүрдүүлэн цалинтай чөлөө олгон ажиллуулж байна.

5.3. Газрын харилцааны чиглэлээр

1814 хадгаламжийн нэгжийн баримтыг цахимжуулан архивын мэдээллийн санд холбосон.

“Газрын төлбөрийн тухай хууль”-д орсон өөрчлөлтийн дагуу 2020 оноос Газрын төлбөрийг газрын төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, газрын даамал ногдуулж, Татварын хэлтэс хураах үүргийг хэрэгжүүлэхээр болсон тул газрын төлбөрийг төвлөрүүлэх, хураах талаар сум хариуцсан татварын байцаагч нарт аймгийн татварын хэлтсээр дамжуулан нэгдсэн нэг чиглэл өгч хамтран ажиллаж байна.

2020 оны 3-р сарын 30-ны байдлаар нийт 1828 нэгж талбарын нэхэмжлэлийг үүсгэж Татварын удирдлагын нэгдсэн системд илгээж 6,500,000 төгрөг газрын төлбөрийг төлүүлсэн.

Коронавирусын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 оны хоёрдугаар сарын 13-ны өдрөөс эхлэн Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдалд хэсэгчлэн шилжүүлсэнтэй холбогдуулан “Газар эзэмшүүлэх дуудлага худалдаа явуулах тухай” А/42, “Газрын дуудлага худалдаа явуулах ажлын хэсэг байгуулах тухай” А/111 дүгээр захирамжуудыг тус тус хүчингүй болгосон.

Барилга, хот байгуулалтын сайдтай 2020 онд хамтран ажиллах гэрээний биелэлтийг хангах ажлын хүрээнд сумдын нутаг дэвсгэрт байгаа геодезийн байнгын цэг тэмдэгтийн бүрэн бүтэн байдлыг шалгаж хол, ойрын фото зургаар баталгаажуулан тооллого явуулах, данс бүртгэлд авах ажлыг 2020 оны 08 дугаар сард багтаан зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт даалгалаа.

5.4. Ус, цаг уур, орчны шинжилгээний чиглэлээр:

Коронавирусээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх захирамжийг нийт ажилчдад танилцуулж хөдөөний ажилчдад цахимаар явуулав.

Коронавирусын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллагын цэвэрлэгээ, ариутгалыг цаг тутам хийж байгаа. Энэ вирустай холбогдуулан байгууллагын 1 дэх өдөр явуулах сургалтыг нийт ажилчдад цахимаар явуулж байна.

Тус төвийн 81 ажилчдад эрсдэлээс урьдчилан сэргийлж амны хаалт, дархлаажуулалт, витаминжуулалт, өрөө тасалгааны халдваргүйтэл, ариутгалын бодис, уусмалын зардалд зарцуулж амьсгалын замын цочмог халдварт томуу, томуу төст өвчний тархалт, шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулан ажиллах зорилгоор ажилчдын 3 дугаар сарын цалинд хоолны мөнгө тооцож олгосон.

Ажлын тусгай горимд шилжсэнтэй холбогдуулан шуурхай штаб байгуулж, жижүүрийн хуваарь гаргаж өдөр бүр өглөөний 09:00 цагт мэдээллийг аймгийн шуурхай штабт хүргүүлж байна.

5.5. Барилгын ажлын чиглэлээр

24 төрлийн импортын барилгын материал болон орон нутагт үйлдвэрлэсэн 45 барилгын материалын мэдээллийг бүртгэн, төв болон орон нутгийн удирдлагыг мэдээллээр ханган ажилласан.

28 төрлийн Барилгын материал, хийц бүтэцийн дээжийг хүлээн авч сорилт шинжилгээ хийж, дүгнэлт гаргаж өгсөн.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 30-ний өдрийн 1/273 тоот албан бичгийн дагуу 2020 оны 02 дугаар сарын 10-ний өдрийн өглөөний 09:00 цагт Баян-Өлгий аймаг дахь Шинжлэх ухааны академийн Одон орон, геофизикийн хүрээлэнд байршуулсан GNSS-ийн байнгын ажиллагаатай станцыг хэвийн ажиллагаанд оруулсан болно.

5.6. Дэд бүтцийн чиглэлээр

5.6.1. Цахилгаан хангамжийн талаар

Аймгийн хэмжээнд Баруун бүсийн эрчим хүчний системээс 8687.0 мян.кВ.цаг цахилгааныг худалдан авч, 7743.0 мян.кВ.цаг цахилгаан худалдан борлуулсан. Нийт 944.0 мян.кВ.цаг цахилгааныг шугамд алдсан. Нийт алдагдал 10.9%-тай байгаа. Худалдан борлуулсан цахилгаанд 1252.0 сая төгрөгийн нэхэмжлэл бичиж, 977.0 сая төгрөгийг цуглуулсан. Борлуулалтын орлого 78,0%-ийн цуглуулгатай байна.

5.6.2.Аймгийн радио телевизийн сүлжээний ажлын талаар

Сар бүр ажилчдын хурал, долоо хоног бүр чанарын хурлыг тогтмол хийж, тухайн үеийн ажилд дүгнэлт хийж ажиллав.

Радио болон тоон ТВ – ийн станцуудын ажиллагаанд хяналт тавьж гарсан гэмтэл саатлыг шуурхай засварлаж, сар бүр үзлэг үйлчилгээ хийж байна.

Сумууд дахь тоон ТВ – ийн тоног төхөөрөмжүүд гэмтсэн үед тухай бүр засварласан. Антенны хашаагаар явж үзлэг хийж, шаардлагатай газарт шинээр хориглох тэмдэг тавьсан. Гамшигаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийсэн.

5.6.4. Усны талаар

Айл өрх, орон сууцны хэрэглэгчээс доторх болон гадна бохир усны шугам бөглөрсөн дуудлага 15, гадна бохир усны шугам хөлдсөн дуудлага 10, бохир усны гэмтлийн дуудлага 5, гадна бохир усны хөлдсөн дуудлага 6, нийтдээ 36 дуудлагыг хүлээн авч бүрэн барагдуулсан.

Коронавирус халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Олон улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Монгол Улсын засгийн газрын 2016 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр” -ийн хүрээнд “Хариуцлагатай хэрэглэгч” сэдвийн дор төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэн тайлан мэдээллийг Хот суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлд явуулав.

Хэрэглэгчдэд түгээж буй ундны уснаас АМХГазрын лабораторид дээж өгч, химийн болон бактериологийн шинжилгээ хийлгэж, шинжилгээний үр дүнд тус компанийн дотоод хяналтын шинжилгээний үр дүнтэй харьцуулж ажиллав. Ундны ус нь MNS ISO900-2018 стандартын шаардлагыг бүрэн хангасан ус байна.

Өндөржүүлсэн бэлэн байдлын үед хэрэглэгчээс ирж буй дуудлага, гомдлыг шуурхай барагдуулахад онц анхаарч, ажлын хариуцлага, сахилга батыг чанд сахин ажиллаж байна.

5.6.6. Нисэх буудлын үйл ажиллагааны талаар

2020 ий 02 дугаар сарын 26-аас 03 дугаар сарын 22-ны өдөр нийт 10 агаарын тээврийн хэрэгсэл “Хүннү-Эйр” ОХЕ-ийн 6 рейсийн агаарын тээврийн хэрэгсэл 181 өрөөл, 31 агаарын тээврийн хэрэгсэл 14, агаарын тээврийн хэрэгсэл 316 ш, гар тээш 228 ш, 9ш шуудан “Аудит-Итгэл” ОХЕ-ийн 4 агаарын тээврийн хэрэгсэл 99 өрөөл, 9, агаарын тээврийн хэрэгсэл 10, агаарын тээш 153 ш, гар тээш 116 ш, 16ш шуудан, 347 нийт зорчигч, агаарын тээврийн хэрэгсэл

сүддээ 39, айу ааааааа 24, ш нийт ачаа, гар тээш 813 ш, 25ш шуудан байна. Нисэх буудлын ажилчид МХГ, Өрхийн эмнэлэг, Авиа компаний ажилчдыг давхардсан тоогоор 286 удаа аюулгүй байдлын үзлэгт хамруулав. Нэг удаагийн түр үнэмлэхийг 26 хүнд олгов.

Өдөр бүрийн бэлэн байдлын мэдээг цаг тухайд нь явуулж байв. Бүх тоног төхөөрөмжүүдэд үзлэг үйлчилгээ хийж ямар нэгэн сааталгүй ажилласан болно.

ЗУРГАА. СУМ, ОРОН НУТГИЙН ТАЛААР

1. АЛТАЙ СУМ

Энэ сард сумын Засаг даргын захирамжаар Онцгой комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан ба “Шуурхай штаб байгуулах тухай” Засаг даргын А/23 дугаар захирамж гарч, сумын Шуурхай штабыг тогтмол ажиллуулан аймгийн Шуурхай штабын 70427049 утасны дугаарт өдөрт 3-4 удаа мэдээлэл өгч ажиллаж байна.

Мөн аймаг, сум хоорондын зорчигч тээврийн хөдөлгөөнийг түр зогсоох тухай сумын Засаг даргын А/36 дугаар захирамж гаргаж, аймгаас өгсөн чиглэлийг мөрдөж ажилласан.

Хаваржилтын бэлтгэл ажлыг хангах хүрээнд сумын онцгой комиссын бүрэлдэхүүн тус сумын бүх албан байгууллага, аж ахуйн нэгж, хөдөө багийн иргэдийн ахуйн амьдралтай танилцан зөвлөмж өгч ажиллав.